



БАТЛАВ:
“МОНКОУЛ ПЕТРО МАЙНИНГ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭГЭГЭХ ЗАХИРАЛ

Н. МӨНХДАШ



БАТЛАВ:
“АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК-
ИЙН ГҮЙЦЭГЭХ ЗАХИРАЛ

Ш. БАЯНМӨНХ

НҮҮРС ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

2022 оны ⁰⁷... дугаар сарын ²⁹...өдөр

Дугаар... ⁸⁷... ²⁰²²

Улаанбаатар хот

Нэг талаас “Монкоул петро майнинг ХХК”-ийг төлөөлж **Ерөнхий нягтлан бодогч ажилтай Ю. Түвшинтөгс** /цаашид Худалдагч гэх/ нөгөө төлөөс “Амгалан дулааны станц” ТӨХК-ийг төлөөлж **Ерөнхий инженер Э.Мөнхжаргал** /цаашид Худалдан авагч гэх/ нар Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, Монкоул петро майнинг ХХК-ийн 22/151 дугаартай албан тоотыг үндэслэн энэхүү гэрээг дараах нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Нийтлэг зүйл

1.1 “Монкоул петро майнинг” ХХК нь “Амгалан дулааны станц” ТӨХК-д гэрээний хугацаанд **100,000** /Нэг зуун мянган/ тонн нүүрсийг зууханд горимын туршилтаар, хавсралтанд заасан хуваарийн дагуу гэрээнд заасан үнээр нийлүүлнэ.

1.2 Гэрээний хугацаанд Худалдагч нь гэрээний 2.1-д заасан стандартын шаардлагад нийцсэн нүүрсийг гэрээний хавсралтад заасан хуваарийн дагуу нийлүүлэх, Худалдан авагч нь нийлүүлсэн нүүрсний төлбөрийг төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.3 Нүүрсний тооцоог 2 байгууллагын тооцооны ня-бо нар дараа сарын 3-ны дотор хийж актаар баталгаажуулна.

1.4 Энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналаа талуудын оролцоотойгоор тухай бүрд нь шийдвэрлэнэ. Шийдвэрийг бичгээр гаргана.

Хоёр. Худалдагч талын үүрэг, эрх, хариуцлага

2.1 Худалдагч тал нь нүүрсийг Худалдан авагч талын зууханд туршиж дүгнэлт гаргасан байх ба нүүрсний чанар, техникийн нөхцлийн дагуу чийглэг нь 38%-аас ихгүй, илчлэг нь 3000 ккал/кг-аас багагүй, 4500 ккал/кг-аас ихгүй, технологийн дамжлагаар оруулан ангилж буталсан 0-50 мм-ийн бутармагтай, шавар чулуулгийн хольцгүй нүүрсийг хавсралтанд заасан хуваарь болон сар бүрийн УБТЗ-ын ачаа тээврийн төлөвлөгөөний дагуу нийлүүлнэ.

2.2 Нүүрсийг техникийн паспортын дагуу вагоны даацанд хүргэж ачих үүрэг хүлээнэ.

2.3 Худалдагч талын давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлийн улмаас нүүрс нийлүүлэх боломжгүй болсон тохиолдолд Худалдан авагч талд 7-10 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.

2.4 Худалдагч тал нь илгээх нүүрсний чийглэг, илчлэгийг Худалдан авагч болон худалдагч талын лабораториудын дундажаар шинжлэн тогтооно. Хэрэв Худалдагч талд лабораторь байхгүй бол Худалдан авагч талын нүүрсний лабораторийн дүнгээр тооцоо хийнэ.

2.5 Нүүрсний овор хэмжээ болон чанар зөрчигдөх, вагон ачилт дундуур, төмөр, механик хольц, шавар, чулуу, шороо, хайрга ачигдаж ирсэн тохиолдолд тэдгээрийн улмаас үүсэх тоног төхөөрөмжийн эвдрэлийн хохирлыг талуудын төлөөлөгчид станц дээр очиж холбогдох хүмүүсийг байлцуулан комисс томилж акт тогтоож шийдвэрлэнэ. Буруутай тал хохирол, гарсан зардлыг бүрэн хариуцна.

2.6 Худалдагч талын падаан бичигч нь төмөр замын Ачаа тээврийн үйлчилгээний цахим систем (АТҮЦС) программ ашиглан бичиг баримтуудыг цахимаар солилцож үнэн зөвөөр бичиж хугацаанд нь Хүлээн авагчид илгээнэ. Энэ нь тооцоо нийлэх үндсэн баримт болно.

2.7 Худалдан авагч талын шаардлагаар нийлүүлэх нүүрсний фракц болон нүүрсний хатаалга хийгдсэн, шигшиж ангилсан чанартай нүүрсээр хангана.

2.8 Худалдан авагчаас шалтгаалан гэрээний хавсралтанд заасан хуваарийн дагуу нүүрс худалдан аваагүй бол Худалдагч нөхөн нийлүүлэхгүй байж болно.

2.9 Худалдагч талаас шалтгаалан хуваарийн дагуу нүүрсээ нийлүүлж чадаагүй тохиолдолд Худалдан авагчийн саналыг үндэслэн нийлүүлээгүй нүүрсийг дараа саруудад нөхөн нийлүүлж болно.

2.10 Худалдагч нь сайтар цэвэрлэсэн вагонд нүүрс ачих ажлыг Төмөр замын өртөөтэй /Мааньт өртөө/ хамтран зохион байгуулна. Хэрэв төмөр, экскаваторын шүд, эд анги ачигдаж станцын тоноглолд гэмтэл учруулбал хоёр талын эрх бүхий техникийн комисс хамтран акт тогтоож шийдвэрлэнэ.

2.11 Худалдагч нь УБТЗ-н вагон үзэгч нартай хамтран үзлэг хийж гэмтэлтэй вагонд нүүрс ачихгүй байх үүрэг хүлээнэ

2.12. Нүүрстэй хамт тээвэрлэгдэж ирсэн гадны биетээс болж /чулуу, төмөр/ бутлуур болон тоноглол эвдэрсэн нь 2.5-д заасан техникийн коммиссоор тогтоогдвол Худалдагч тал засварлах зардлыг хариуцна.

2.13. Дулааны станцын төмөр замын хүчин чадалд тааруулж өртөөнөөс нүүрстэй вагоныг тогтмол 8-16 вагоны цуваагаар явуулж байна.

Гурав. Худалдан авагч талын үүрэг, эрх, хариуцлага

3.1 Гэрээнд заасан хугацааны дотор худалдан авсан нүүрсний үнийг төлөх үүрэгтэй.

3.2 Гэрээгээр тогтоосон чанар стандартад нийцсэн нүүрс нийлүүлэхийг шаардах эрхтэй.

3.3 Гэрээгээр тохиролцсон **100,000** тонн нүүрсийг хүлээн авч, төмөр замын “Мааньт” өртөөнөөс цааших тээвэрлэлттэй холбоотой зардал, хариуцлагыг хүлээнэ.

3.4 Нийлүүлэх нүүрсний суурь илчлэгийг 3250 ккал/кг-аар тооцоонд авах бөгөөд 1 тонн эрчим хүчний технологийн нүүрсний үнийг 36410 төгрөг, 1 ккал/кг-ын үнийг 11.2 төгрөгөөр тооцно. Нүүрсний илчлэг 3250 ккал/кг-аас доош илчлэгтэй нүүрсний үнийг тооцохдоо лабораторийн шинжилгээний тухайн сарын дундаж илчлэгийг 1 ккал/кг-ын үнээр үржүүлж тооцно. 3350 ккал/кг-аас дээш илчлэгтэй нүүрсэнд илчлэгийн зөрүү тооцохгүй.

3.5 Хавсралтад заасан нүүрсний хэмжээнд өөрчлөлт оруулах тохиолдолд Худалдагч талд урьдчилан 7-оос доошгүй хоногийн өмнө албан бичгээр болон байгууллагын цахим хаягаар мэдэгдэнэ.

3.6 Нийлүүлэгдсэн нүүрс гэрээний 2.1-д заасан шаардлага хангаагүйн улмаас Худалдан авагч талын тоног төхөөрөмжид эвдрэл, саатал гарч компанид хохирол гарсан тохиолдолд 2.5-д зааснаар комисс томилж акт тогтоож хохирлыг нэхэмжилнэ.

3.7 2900 ккал/кг-аас бага илчлэгтэй, механик хольтой, чийглэг нь 40%-аас дээш гарсанаас болж хөлдөж наалдсан, шавар, чулуу, шороо ихтэй ирсэн тохиолдолд тухайн компанид мэдэгдэн вагонтой нүүрсийг буцаах ба үүнээс үүдэн гарсан бүх зардлыг Худалдагч тал хариуцна. /2 талын тээвэрлэлт, вагон таталт тавилт, хүлээлэлт, хаяг солилт г.м /

3.8 Нүүрсний шавар, чулуулгын хольцын хэмжээ гэрээний 2.1 болон 2.5-д заалт зөрчигдвөл тусад нь ялгаж нүүрсний тооцоо хийхдээ нийлүүлсэн нүүрсний хэмжээнээс хасч тооцно.

3.9 Худалдагч талаас илгээсэн нүүрсэнд Худалдан авагч тал нүүрсний сорьц авч шинжилгээг хийж баталгаажуулан, сарын эцэст нүүрсний тооцоонд шинжилгээний хариуг ашиглана.

3.10 Худалдагч талаас нийлүүлсэн нүүрсийг Худалдан авагч талын вагон жингээр пүүлж хяналт тавьж нүүрс нийлүүлэлтэд зөрүү гарвал 2 талын вагон жингийн дундажаар тооцно.

3.11. Төмөр замын тээврийн хөлсийг станц, төмөр замын Мааньт болон Амгалан өртөөний хооронд сар бүр хийсэн тооцоог үндэслэн Худалдан авагч төлж нүүрс тээврийн захиалга өгөх нөхцлийг бүрдүүлнэ. Төмөр замд төлбөр хийгдээгүйн улмаас вагон хангалтын асуудлыг Худалдан авагч бүрэн хариуцна. Нүүрс болон вагон захиалганд зохицуулалт хийхэд харилцан хоорондоо урьдчилан мэдэгдэнэ.

Дөрөв. Төлбөр тооцоо, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

4.1 1 тонн технологийн нүүрсний үнийг **36410 /Гучин зургаан мянга дөрвөн зуун арав/** төгрөгөөр тооцно. НӨАТ-атварыг 1 тонн нүүрсний үнэ дээр нэмж тооцно.

4.2 Худалдан авагч тал нь тухайн сард нийлүүлэгдэх нүүрсний төлбөрийн тооцоо нийлж дараа сарын 20-ны дотор Худалдагч талын харилцах дансанд бүрэн шилжүүлнэ. Төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд төлөгдөөгүй үлдсэн нүүрсний үнийн дүнгээс хугацаа хэтэрсэн хоног тутамд 0.1%-ийн алданги тооцож төлнө. Худалдагч тал нь гэрээний дагуу сард нийлүүлэх нүүрсээ бүрэн гүйцэд нийлүүлээгүй тохиолдолд дутуу нийлүүлсэн нүүрсний үнийн дүнгийн 0.1%-аар хоног тутамд алдангийг Худалдан авагч талд төлнө. Алдангийн нийт хэмжээ төлбөл зохих нийт нүүрсний төлбөрийн 20%-аас хэтэрч болохгүй.

4.3 Талууд сарын хуваарийн дагуу нүүрсний захиалга, нийлүүлэлт, хүлээн авалтыг жигд хийж байх ба тэдгээрийг гүйцэтгээгүйн улмаас үүсч болох хохирлыг буруутай тал хүлээнэ.

4.4 Гэрээний 4.2-т заасан хугацаанд Худалдан авагч төлбөрийг бүрэн барагдуулаагүй тохиолдолд ажлын 5 хоногийн дотор төлбөр нэхэмжлэх мэдэгдэл Худалдагч талаас хүргүүлнэ. Худалдан авагч тал төлбөрийн нэхэмжлэх хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор төлбөрийг бүрэн барагдуулаагүй тохиолдолд Худалдагч тал нүүрсний дараагийн нийлүүлэлтийг зогсоож болно.

Тав. Давагдашгүй хүчин зүйл

5.1 Худалдагч ба Худалдан авагч талууд гэрээнд заагдсан үүргээс бүрэн ба хагас чөлөөлөгдөх нөхцлүүд байна. Тус гэрээний биелэлтэд нөлөөлж, үүргээ давагдашгүй хүчин зүйлийн улмаас биелүүлэх боломжгүй нөхцөлд /Үүнд: гал түймэр, үер, газар хөдлөлт ба дайны

үйл ажиллагаа/ давагдашгүй хүчин зүйл, түүний үр дагавар дуусах хүртэл тус гэрээний биелэлтийн хугацаа сунгагдана.

5.2 Давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний үүргээ биелүүлж чадахгүй болсон тал давагдашгүй хүчин зүйл эхэлснээс 2 хоногийн дотор нөгөө талд бичгээр мэдэгдэнэ.

5.3 Давагдашгүй хүчин зүйл тохиолдсоныг Худалдаа аж үйлдвэрийн танхимын албан бичиг (тодорхойлолт) нотолно.

Зургаа. Бусад нөхцөл

6.1 Хэрэглэгчдийн эрчим хүчний өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг хангах зорилгоор төлөвлөгөөнөөс илүү үйлдвэрлэл явуулахад технологийн хэрэгцээний нүүрс нэмж шаардагдвал энэхүү гэрээний хавсралтад нийлүүлэх нүүрсний хуваарьт албан тоотoor өөрчлөлт оруулж мөрдөнө.

6.2 Технологийн саатал, осол гарах, техникийн хүндрэл гарах зэрэг тохиолдолд гэрээ хийсэн талуудын төлөөлөгчид хамтран хэлэлцэж саадыг даван туулах, гэрээний заалтад өөрчлөлт оруулах шийдвэрийг протоколоор гаргана. Энэ шийдвэр нь гэрээний эцсийн биелэлтэнд нөлөөлөхгүй.

6.3 Энэхүү гэрээ нь 2022 оны 7 дугаар сарын 28 -ний өдрөөс эхлэн 2023 оны 05 дугаар сарын 15-ний өдөр хүртэл хүчинтэй байна. Гэрээг үргэлжлүүлэн сунгах эсвэл шинээр гэрээ байгуулах тухай хэлцэл явагдаж байх хугацаанд энэхүү гэрээг мөрдөнө. Гэрээнд оролцогч аль нэг тал нь гэрээг үргэлжлүүлэн мөрдөхөөс татгалзаагүй тохиолдолд хүчин төгөлдөр гэж үзнэ. Гэрээ нь харилцан баталсан өдрөөс хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

6.4 Гэрээг улирал бүр дүгнэх бөгөөд 2 тал харилцан тохиролцож гэрээ дүгнэсэн акт үйлдэнэ.

6.5 Гэрээний хувь нь талуудад тус бүрд 1 хувиар хадгалагдах бөгөөд гэрээтэй холбогдсон, акт протоколын хувиудыг талуудад хадгалагдана. Гэрээ дүгнэсэн, сунгасан, нэмэлт оруулсан баримт бичгүүд нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.

6.6 Талууд сарын хуваарийн дагуу вагон захиалалт, нийлүүлэлт, татан авалтыг шуурхай гүйцэтгэж гэрээний үүргээ биелүүлэх ба аль нэг талын буруутай үйл ажиллагаанаас үүссэн хохирлыг буруутай тал нь хүлээнэ.

6.7 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, мөрдөж ажиллах бөгөөд гэрээтэй холбоотой маргаан гарвал 2 тал аль болох эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Хэрэв тохиролцохгүйд хүрвэл хууль, хяналтын байгууллагаар асуудлыг шийдвэрлүүлнэ.

Долоо. Гэрээг цуцлах

7.1. Гэрээг хуульд зааснаас гадна дараах үндэслэлээр нэг талын санаачлагаар цуцлаж болно.
 А. Аль нэг тал гэрээ ба хуулиар хүлээсэн үүргээ удаа дараа зөрчсөн ба үүнээс болж нөгөө тал нь хохирол хүлээсэн нь баримтаар нотлогдсон бол хохирол хүлээсэн талын санаачлагаар.
 Б. Нүүрсний чанарын үзүүлэлт гэрээнд заасан үзүүлэлт зөрчигдөж байгаа бол Худалдагч талд албан тоотoor мэдэгдэж чанарын үзүүлэлтийг сайжруулахгүй бол Худалдан авагчийн санаачлагаар гэрээг цуцлана.
 В. Худалдагчийн нийлүүлэх нүүрсний нөөц дууссан буюу Худалдагч гэрээгээр хүлээсэн нүүрс нийлүүлэх үүргээ биелүүлэх боломжгүй бол 7-10 хоногийн өмнө Худалдан авагч талд албан тоотoor мэдэгдэж гэрээ цуцлах эрх үүснэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Ерөнхий нягтлан бодогч




Ю. Түвшинтөгс

Хуулийн мэргэжилтэн



С. Дагиймаа

Ашиглалтын инженер



Х. Цогбаяр


ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

СЭЗХ-ийн дарга бөгөөд ерөнхий
нягтлан бодогч




Ө. Удвал

Ахлах инженер



Б. Батцоож

Зуухан цехийн дарга



Э. Ариунболд

Түлш дамжуулах цехийн ашиглалтын
инженер



Д. Түвшинзаяа

Хуулийн мэргэжилтэн



Г. Саруул

Хаяг:

Улаанбаатар хот, БЗД, 1-р хороо,
12-р хороолол

Royal Castle-101-1201 тоот

Мэйл хаяг: moncoalmining@gmail.com

Данс: Голомт банк 2205146279

Утас: 99114498, 990380588, 99054677

Хаяг:

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
8-р хороо УС-1-1, "Амгалан дулааны
станц" ТӨХК

Утас: 77111242, 99047300, 99662289

Данс: Төрийн банк 106000036534

Хаан банк 5131101050

Голомт банк 3105103284

.....Тоот гэрээний хавсралт

“Монкоул Петро Майнинг ХХК”--аас “Амгалан Дулааны Станц”-ТӨХК-д

нийлүүлэх нүүрсний хуваарь

д/д	Үзүүлэлт	х/н	2022 он				Нийт
			09 сар	10 сар	11 сар	12 сар	
1	Нүүрс	тн	8056.24	8343.41	8472.31	8638.28	30000
2	Төлөх төлбөр	м.т	293,327.7	303,783.5	308,476.9	314,519.7	

д/д	Үзүүлэлт	х/н	2023 он					Нийт
			01 сар	02 сар	03 сар	04 сар	05 сар	
1	Нүүрс	тн	7892.0	12597.8	17868.7	16439.9	11702.2	70000
2	Төлөх төлбөр	м.т	287,346.7	458,684.3	650,598.1	598,578.3	426,841.7	



ХУВААРЬ ГАРГАСАН:

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
 Н.Гомбосүрэн
 Горимын хяналт, тооцооны инженер